

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	3
2.1	Оршил .....	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	3
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	3
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	4
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	6
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	11
3	Менежментийн захидал	9
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	11

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.03.07 № 06/399  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

ШУА-ийн Хими, Хими технологийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар ШУА-ийн Хими,Хими технологийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ШУА-ийн Хими, химийн технологийн захирал Л.Жаргалсайхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт, зардал, нягтлан бодох бүртгэлийн бодлого үйл ажиллагааг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 10 сарын 03-наас 2019 оны 02 сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Шонхор үнэлгээ аудит” ХХК-ийн аудитын баг хариуцан хэрэгжүүлэв.

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 01 сарын 23-ны өдрийн 1/35 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат, шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэн нь Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн химийн аж үйлдвэрийг хөгжүүлэх шинжлэх ухааны үндэслэлийг бий болгох, химийн шинжлэх ухааныг шинэ мэдлэг, мэдээллээр баяжуулахад оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгчийн 2017 оны А/73 дугаар тушаалаар ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Химийн шинжлэх ухааны суурь судалгаа явуулж, захиалгат болон судалгааны бусад төслүүдийг гүйцэтгэх замаар судалгаа-боловсруулалтын ажлын үр дүнг амьдрал практикт нэвтрүүлэх;
- Бусад эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуульд хийгдэж байгаа судалгаа шинжилгээний болон сургалтын ажилд оролцох, эрдэмтдийн залуу халааг бэлтгэх;
- Олон улс, бүс нутаг, гадаад орнуудын болон дотоодын аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран судалгаа шинжилгээний ажил хийх, түүний үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, худалдах, патентлах;
- Эрдэм шинжилгээний хурал, симпозиум, сургалт, семинар зохион байгуулах, ном бүтээл хэвлэх;
- Зохих зөвшөөрлийн дагуу дангаараа болон бусад байгууллагатай хамтран туршилт үйлдвэрийн цех байгуулах;
- Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үндэслэн төр, засгийн байгууллага, аж ахуйн нэгжид санал, зөвлөмж хүргүүлэх, үйл ажиллагааны үр дүнг тогтоосон хугацаанд ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт тайлагнах.

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Шинжлэх ухаан, технологийн тухай
- Инновацийн тухай хууль
- Технологи дамжуулах тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болохыг тайланд тэмдэглэв.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус хүрээлэнгийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзсэн. БСШУС-ын сайдын 2017 оны А/40 тоот тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлдээ мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох груп” ХХК-ийн Acolous 3.0 програм хангамж ашигладаг байна.

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хариуцсан ажилтангүй болно.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг 1 хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Төсөвт байгууллагын үйл ажиллагааг илүү сайн илэрхийлж чадах үзүүлэлт нь төсвийн санхүүжилт байдаг. Тус хүрээлэн нь 2018 онд нэмэлтээр НҮБ-ийн байгаль орчны хөгжлийн сан, Шинжлэх ухаан технологийн сан гэсэн байгууллагуудаас нэмэлт санхүүжилт авсан зэргийг харгалзан нийт орлогын үзүүлэлтийн 1 хувиас хэтрэхгүй дүнг материаллаг бус гэж үзсэнтэй холбоотой юм.

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2018 оны нийт орлого 3,004,183.9 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 30,041.84 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь ажил гүйлгээ ба чанар байдлыг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	19,034.9	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 “эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах,” гэсэн заалттай нийцүүлэх, Улсын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, худалдан авах ажилллагааны хуулийг хэрэгжүүлж ажиллах, Хөрөнгийн тооллогыг үр дүнтэй хийх
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.0	
3	Албан шаардлага өгсөн	0	0.0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.0	
	Дүн	3	19,034.9	

**2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**  
Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

**2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 3 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,643,818.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,637,632.8 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь 2018 онд 6,185.9 мянган төгрөгийн урсгал зардлын хэмнэлт үүссэн. Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу дотоод хяналт тавьж, арвилан хэмнэлттэй зарцуулсны үр дүнд хэмнэлт үүссэн байна.

Тайлант онд 16,600.0 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдаж, гүйцэтгэлээр 21,380.2 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг харилцах дансандаа төвлөрүүлэн орлогын төлөвлөгөөг 128.8 хувиар давуулан биелүүлж, Сангийн яамны зөвшөөрлийн дагуу давсан орлогоос 3,715.7 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна. Үүнийг тодруулбал үндсэн үйл ажиллагааны 18,423.4 мянган төгрөгийн шинжилгээний орлого, 2,956.8 мянган төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлсэн байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус хүрээлэнгийн Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан шилэн дансны мэдээллийг шалгаж үзэхэд 20 мэдээлэл оруулахаас 9 мэдээллийг оруулаагүй.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ оруулах мэдээллийн эхний 9 сарын болон 11 саруудад, мөн хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийн оны эхний 9 сарын мэдээллүүдийг хугацаа хожимдуулсан байна

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 94 хувьтай байна.

2018 онд санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийн биелэлт 100 хувь, 2 зөвлөмжийн биелэлт 80-90 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт

##### 3.1.1 Илрүүлэлт:

Тайланд хугацаанд худалдан авах ажиллагааны “босго үнэ”-ээс бага үнийн дүнтэй нийт 14,121.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авах гэрээг 4 удаа байгуулсан байна.

Энэ нь нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

##### 3.1.2 Эрсдэл:

Тендер зарлахгүйгээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан байх

##### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллах

##### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрч, цаашид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно

#### 3.2 Зардлын данстай холбоотой асуудал

##### 3.2.1 Илрүүлэлт:

Цалин хөлсийг түүвэр байдлаар давтан тооцоолж шалгаж үзэхэд дараах асуудлууд илэрлээ.

- Байгууллагын дотоод журамд тусгасанаар цалинг сард 1 удаа тавьж олгож байгаа нь цалинтай холбоотой үүссэн тооцоог дараа сард залруулах боломжгүй байдал үүсдэг.

- Төрийн үйлчилгээний албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, эрхэлсэн ажилдаа гаргасан амжилтыг үл харгалзан сар бүр бүх хүнд ур чадварын нэмэгдэл хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Эрх ба үүрэг, үнэн зөв байдал, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д “Ажилтны цалин хөлсийг сард хоёр ба түүнээс дээш удаа, тогтоосон өдөр олгоно” гэж заасантай, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-д заасантай тус тус нийцэхгүй байна.

### 3.2.2 Эрсдэл:

Цалингийн өглөг, авлага үүсэх, төсвийн хөрөнгө зүй бусаар ашиглагдах

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын холбогдох заалтыг мөрдөж ажиллах

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрч, цаашид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно

## 3.3 Балансын данстай холбоотой асуудал

### 3.3.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн бүртгэлд хийсэн сорилоор

- Бага оврын 4,913.0 мянган төгрөгийн үнэтэй тракторыг 2,200.0 мянган төгрөг, 2,713.0 мянган төгрөгөөр салгаж бүртгэсэн.
- 2015 оны сүүлээр тус хүрээлэнтэй нэгдсэн Эрдсийн технологийн лабораториос бүртгэлээр шилжиж ирсэн өөрөө буулгагч краз 256б автомашины маргаантай асуудлаар шүүхийн шийдвэр гарсан боловч хөрөнгө биетээр байхгүй байна.

Энэ нь Оршин байх, Эрх ба үүрэг, Топилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдэлүүдтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т “эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах;” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана ” гэж заасантай нийцэхгүй байна.

### 3.3.2 Эрсдэл:

Хөрөнгийн бүртгэлээр тавих хяналт сулрах

### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь заалтыг тус тус мөрдөж ажиллах

### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрч, цаашид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний Аудитын газарт 2019 оны 07 дугаар сарын 01-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа : 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон / төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>279,298,753.64</u></b>	<b><u>229,752,611.20</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	132,175,923.22	120,708,942.49
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	412,944.22	1,854,057.29
3351	Байгууллагаас авах авлага	412,944.22	1,854,057.29
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	68,703,830.00	00.0
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	2,405,900.00	00.0
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	78,419,000.42	109,043,668.71
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	12,491,898.86	12,099,787.36
35110	Тусгай зориулалттай материал	12,491,898.86	12,099,787.36
35300	Бэлэн бүтээгдэхүүн	00.0	15,403,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	65,927,101.56	81,540,881.35
35410	Бичиг хэргийн материал	1,517,867.00	3,112,137.00
35420	Аж ахуйн материал	00.0	13,027,397.00
35430	Сэлбэг хэрэгсэл	48,262,634.20	44,281,842.00
35440	Түлш, шатах тослох материал	217,000.00	217,000.00
35470	Бусад хангамжийн материал	15,929,600.36	20,902,505.35
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,831,346,814.20</u></b>	<b><u>4,926,151,667.76</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,831,346,814.20	4,926,151,667.76
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,830,339,318.39	4,720,012,998.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,662,785,486.10	3,730,009,418.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,117,440,432.51	00.0
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,913,000.00	31,913,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-30,057,926.61	-31,496,333.38
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,158,958,149.37	2,743,555,079.97
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,909,740,198.58	-1,999,580,567.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	141,359,780.25	362,168,105.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	-122,262,967.58	-126,674,351.73
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,900,000.00	2,900,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,117,708.21	-1,480,208.17
39217	Ном	13,042,136.16	8,698,856.16
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,007,495.81	206,138,669.13
39301	Програм хангамж	3,820,000.00	3,820,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,812,504.19	-3,174,170.87
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	205,492,840.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,110,645,567.84</u></b>	<b><u>5,155,904,278.96</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,110,645,567.84</u></b>	<b><u>5,155,904,278.96</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,110,645,567.84	5,155,904,278.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,077,104,818.51	3,282,597,658.51
51101	Өмч: - төрийн	3,077,104,818.51	3,282,597,658.51

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-1,779,390,981.24	-1,193,424,827.57
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,779,390,981.24	-1,779,390,981.24
51220	Тайлант үеийн үр дүн	00.0	585,966,153.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	812,931,730.57	3,066,731,448.02
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,110,645,567.84</u></b>	<b><u>5,155,904,278.96</u></b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа : 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон / төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,113,235,521.62</b>	<b>3,004,183,875.90</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>85,919,751.80</b>	<b>588,341,722.40</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	85,919,751.80	588,341,722.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	85,919,751.80	585,384,922.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,644,660.00	14,707,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	59,275,091.80	570,677,222.40
120005	Түрээсийн орлого	00.0	2,956,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,027,315,769.82</b>	<b>2,415,842,153.50</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,539,285,200.00	1,627,218,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,539,285,200.00	1,627,218,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	488,030,569.82	787,593,762.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	187,364,040.00	375,156,562.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,560,500.00	408,721,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,106,029.82	3,715,700.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	00.0	1,029,691.50
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.0	1,029,691.50
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,915,783,615.33</b>	<b>2,393,462,127.23</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,915,783,615.33</b>	<b>2,393,462,127.23</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,915,783,615.33	2,364,087,296.49
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,216,582,068.08	1,254,439,420.06
210101	Үндсэн цалин	1,216,582,068.08	1,055,887,809.17
210102	Нэмэгдэл	00.0	154,719,983.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.0	37,030,278.49
210104	Урамшуулал	00.0	6,801,349.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	138,409,379.64	148,194,657.52
210201	Тэтгэврийн даатгал	94,145,509.64	103,762,357.71
210202	Тэтгэмжийн даатгал	11,745,500.00	12,255,583.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,312,841.00	9,372,369.67
210204	Ажилгүйдлийн даатгал	2,107,987.00	2,217,527.49
210205	Эрүүл мэндийн даатгал	21,097,542.00	20,586,819.65
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	83,394,199.74	84,212,289.89
210301	Гэрэл, цахилгаан	31,833,459.00	25,903,090.00
210302	Түлш, халаалт	39,521,599.03	44,682,679.00
210303	Цэвэр, бохир ус	12,039,141.71	13,626,520.89
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,774,351.12	41,456,270.33
210401	Бичиг хэрэг	00.00	12,663,775.00
210402	Тээвэр, шатахуун	826,000.00	3,498,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,806,196.12	1,880,816.33
210404	Ном, хэвлэл	399,500.00	230,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	2,940,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,553,315.00	20,243,579.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	189,340.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	00.00	2,070,730.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	2,070,730.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	24,578,900.00	85,895,009.01
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	60,000.00
210604	Урсгал засвар	24,578,900.00	85,835,009.01

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	00.0	3,368,140.00
210701	Гадаад албан томилолт	00.0	2,405,900.00
210702	Дотоод албан томилолт	00.0	962,240.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	204,456,087.18	394,480,031.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	201,920,387.18	391,543,899.99
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,600,000.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,100.00	70,100.00
210807	Газрын төлбөр	865,600.00	866,032.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	242,588,629.57	349,970,747.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,973,679.76	19,322,948.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,874,052.00	189,853,715.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	165,740,897.81	140,794,084.49
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	00.0	29,374,830.74
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.0	21,897,204.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.0	10,273,968.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.0	11,623,236.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.0	7,477,626.74
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.0	7,477,626.74
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>197,451,906.29</b>	<b>610,721,748.67</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.0	24,755,595.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.0	24,755,595.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.0	-24,755,595
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>197,451,906.29</b>	<b>585,966,153.67</b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа : 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон / төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,118,031,643.82</b>	<b>2,564,417,941.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>37,365,371.00</b>	<b>17,664,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	37,365,371.00	17,664,500.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	37,365,371.00	14,707,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,843,360.00	14,707,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,522,011.00	00.00
120005	Түрээсийн орлого	00.00	2,956,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,080,666,272.82</b>	<b>2,546,753,441.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,539,285,200.00	1,627,218,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,539,285,200.00	1,627,218,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	514,791,513.82	919,534,741.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	214,124,984.00	506,919,541.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,560,500.00	408,721,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,106,029.82	3,893,700.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	26,589,559.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	26,589,559.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,892,915,314.47</b>	<b>2,370,772,187.80</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,892,915,314.47</b>	<b>2,370,772,187.80</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,890,312,361.47</b>	<b>2,222,865,280.86</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,243,171,627.08	1,254,762,229.06
210101	Үндсэн цалин	1,189,062,027.08	1,057,327,459.06
210102	Нэмэгдэл	9,435,100.00	154,173,779.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,674,500.00	37,030,737.00
210104	Урамшуулал	00.00	6,230,254.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	138,409,379.64	149,011,779.11
210201	Тэтгэврийн даатгал	94,145,509.64	127,269,654.82
210202	Тэтгэмжийн даатгал	11,745,500.00	5,835,155.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,312,841.00	4,330,041.29
210204	Ажилгүйдлийн даатгал	2,107,987.00	1,047,644.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,097,542.00	10,529,284.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	83,394,199.74	84,212,289.89
210301	Гэрэл, цахилгаан	31,833,459.00	25,903,090.00
210302	Түлш, халаалт	39,521,599.03	44,682,679.00
210303	Цэвэр, бохир ус	12,039,141.71	13,626,520.89
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,734,921.12	40,668,241.33
210401	Бичиг хэрэг	2,275,740.00	1,105,750.00
210402	Тээвэр, шатахуун	1,763,000.00	3,498,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,806,196.12	1,880,816.33
210404	Ном, хэвлэл	849,500.00	20,720,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	2,801,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,040,485.00	10,662,175.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,796,597.00	1,800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,796,597.00	1,800,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	77,971,900.00	73,241,140.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,000,000.00	185,400.00
210604	Урсгал засвар	32,971,900.00	73,055,740.00

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	38,773,300.00	962,240.00
210701	Гадаад албан томилолт	17,239,300.00	00.00
210702	Дотоод албан томилолт	21,534,000.00	962,240.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	255,399,173.89	426,689,583.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	252,863,473.89	423,753,451.47
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,600,000.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,100.00	70,100.00
210807	Газрын төлбөр	865,600.00	866,032.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	36,661,263.00	191,517,778.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,587,211.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,074,052.00	191,517,778.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,602,953.00</b>	<b>147,906,906.94</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,602,953.00	21,897,204.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	10,273,968.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,602,953.00	11,623,236.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	126,009,702.94
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	126,009,702.94
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>225,116,329.35</b>	<b>193,645,753.20</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>225,116,329.35</b>	<b>193,645,753.20</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>225,116,329.35</b>	<b>193,645,753.20</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	225,116,329.35	193,645,753.20
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	225,116,329.35	193,645,753.20
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(225,116,329.35)</b>	<b>-193,645,753.20</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		<b>00.0</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>00.0</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.00	00.0
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		00.0
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		00.0

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа : 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон / төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,077,104,818.51	812,931,730.57	-1,896,733,017.18	1,993,303,531.90
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,077,104,818.51	812,931,730.57	-1,896,733,017.18	1,993,303,531.90
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	197,451,906.29	197,451,906.29
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,077,104,818.51	812,931,730.57	-1,779,390,981.24	2,110,645,567.84
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,077,104,818.51	812,931,730.57	-1,779,390,981.24	2,110,645,567.84
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,077,104,818.51	812,931,730.57	-1,779,390,981.24	2,110,645,567.84
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	2,253,799,717.45	00.00	2,253,799,717.45
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	205,492,840.00	00.00	00.00	205,492,840.00
D08	Тайлант үеийн үр дүн		00.00	585,966,153.67	585,966,153.67
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,282,597,658.51	3,066,731,448.02	-1,193,424,827.57	5,155,904,278.96

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа : 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон / төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,643,818,700.00	1,637,632,805.19	6,185,894.81	99.6%
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,643,818,700.00	1,637,632,805.19	6,185,894.81	99.6%
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,621,921,300.00	1,615,735,601.19	6,185,698.81	99.6%
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,204,965,900.00	1,204,087,016.06	878,883.94	99.9%
210101	Үндсэн цалин	987,312,100.00	1,006,652,246.06	-19,340,146.06	102.0%
210102	Нэмэгдэл	166,875,300.00	154,173,779.00	12,701,521.00	92.4%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,302,400.00	37,030,737.00	8,271,663.00	81.7%
210104	Урамшуулал	5,476,100.00	6,230,254.00	-754,154.00	113.8%
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	145,375,400.00	142,930,754.11	2,444,645.89	98.3%
210201	Тэтгэврийн даатгал	97,068,700.00	121,188,629.82	-24,119,929.82	124.8%
210202	Тэтгэмжийн даатгал	12,076,700.00	5,835,155.00	6,241,545.00	48.3%
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,661,300.00	4,330,041.29	5,331,258.71	44.8%
210204	Ажилгүйдлийн даатгал	2,415,300.00	1,047,644.00	1,367,656.00	43.4%
210205	Эрүүл мэндийн даатгал	24,153,400.00	10,529,284.00	13,624,116.00	43.6%
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	84,905,400.00	84,212,289.89	693,110.11	99.2%
210301	Гэрэл, цахилгаан	34,629,200.00	25,903,090.00	8,726,110.00	74.8%
210302	Түлш, халаалт	36,876,100.00	44,682,679.00	-7,806,579.00	121.2%
210303	Цэвэр, бохир ус	13,400,100.00	13,626,520.89	-226,420.89	101.7%
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,357,000.00	14,356,961.33	38.67	100.0%
210401	Бичиг хэрэг	1,660,000.00	1,105,750.00	554,250.00	66.6%
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,800,000.00	00.00	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,700,000.00	1,880,816.33	819,183.67	69.7%
210404	Ном, хэвлэл	407,000.00	581,820.00	-174,820.00	143.0%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,520,000.00	2,801,400.00	-281,400.00	111.2%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,270,000.00	6,187,175.00	-917,175.00	117.4%
2105	<b>Нормативт зардал</b>	1,800,000.00	1,800,000.00	00.00	100.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.00	1,800,000.00	00.00	100.0%
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	112,177,500.00	112,149,072.80	28,427.20	100.0%
210601	Багаж, техник, хэрэгсэл	58,630,000.00	58,682,072.80	-52,072.80	100.1%
210604	Урсгал засвар	53,547,500.00	53,467,000.00	80,500.00	99.8%
2107	<b>Томилот, зочны зардал</b>	1,000,000.00	962,240.00	37,760.00	96.2%
210702	Дотоод албан томилот	1,000,000.00	962,240.00	37,760.00	96.2%

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	57,340,100.00	55,237,267.00	2,102,833.00	96.3%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,360,100.00	52,301,135.00	2,058,965.00	96.3%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	00.00	100.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	70,100.00	9,900.00	87.6%
210807	Газрын төлбөр	900,000.00	866,032.00	33,968.00	96.2%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	21897400.00	21897204.00	196.00	100.0%
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	21897400.00	21897204.00	196.00	100.0%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,274,000.00	10,273,968.00	32.00	100.0%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,623,400.00	11,623,236.00	164.00	100.0%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,643,818,700.00	1,637,632,805.19	6,185,894.81	99.6%
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,627,218,700.00	1,619,968,305.19	7,250,394.81	88.6%
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,627,218,700.00	1,619,968,305.19	7,250,394.81	88.6%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,600,000.00	14,707,700.00	1,892,300.00	88.6%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,956,800.00	-2,956,800.00	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	127	127		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	99	99		
620003	Үйлчлэх ажилтан	27	27		
620004	Гэрээт ажилтан				

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2018.02.23

Аудитын нэр:

Санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код:

САГ-2019/49/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр:

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэн

мянган төгрөгөөр

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5			9	10
1	Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт	1	Тендер зарлаагүйгээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан	14,121.9	Зөвлөмж өгсөн			Захирал Ерөнхий нягтлан бодогч	Л.Жаргалсайхан Ц.Алтанхуяг
2	Балансын данстай холбоотой	2	Нэг тракторыг 2 үнээр салгаж бүртгэсэн	4913.0	Зөвлөмж өгсөн			Захирал Ерөнхий нягтлан бодогч	Л.Жаргалсайхан Ц.Алтанхуяг
			<b>Нийт</b>	<b>19,034.9</b>					

Баталгаажуулалт

Тайлангийн хураангуй бэлтгэсэн

Аудитор:

Анхан шатны чанарын хяналт

хийсэн: Чанарын хяналтын

менежер

Д.Шийрэв

З.Эрдэнэжаргал



